

МИН УЛСЫН ГАДААД БОДЛОГО БА АЛТАН ХАНТАЙ ХАРИЛЦСАН ДИПЛОМАТ БАРИМТ БИЧГИЙН ТУХАЙД

Д. Ундрах¹

Abstract

Throughout the 15 th and the 16 th centuries, the Mongols were scourge of the Northern Chinese border areas, and they grew ever bolder and more aggressive as the military organization of the Ming weakened and financial difficulties increased. Attacks were most frequent from around 1540 on; In the circles of historiography, the research on Altan Khan is of considerable significance, for it constitutes an indispensable component of the entire Mongolian historical research. The research on Altan Khan shall not only involve the evaluation on his merits and demerits in his life and the historical role he has played, but also, more importantly, shall help us get a clear picture of the complex period in Mongolian history after Altan Khan. We are find a few Chinese documents discussed in the following pages are: 1. an imperial rescript from 1571 whereby Altan Khan, the chieftain of the Twelve Tumed Mongols in the region of modern Suiyuan, was granted the title of Shun Yi wang ; 2. an imperial rescript granting honorary military ranks to sixty-three Mongol nobleman, all relatives or subjects of Altan Khan, whose names also appear as co-signatories of the document.

Key words: Ming Dynasty; Altan Khan ; Documents of Min-Mongols relationship

Түүхэн эх сурвалж ховор хомс учир Мин улс, Төв Азийн харилцааг судлахад ихээхэн саад бэрхшээл тулгардаг. Төв Азийн болон Перс хэл дээрх эх сурвалжуудад ялангуяа тэр үеийн Төв Азийн нэн чухал сурвалж Tarkih-i-Rashidi дотор Хятадын тухай бичсэн зүйл ховор байх бөгөөд Төв Ази хийгээд Хятадад ирж байсан элчийн тэмдэглэлд Мин улсын хааны ордонд төрсөн гүнзгий сэтгэгдлүүдээ бичиж үлдээсэн байдаг нь үнэтэй сурвалж болдог. Гэвч Хятад болон Төв Азийн улс хоорондын гадаад харилцааны тухай тэмдэглэл бараг байдаггүй гэж хэлж болох юм. Тиймээс Мин улсын түүхийг судлаачид Хятад эх сурвалжид тулгуурлахаас өөр аргагүй болдог билээ. Харин хятад эх сурвалжууд эмх замбараа муутай, эрээвэр хурааврын дээр эртний хятад хүн бусад гадаад улс гүрнүүдийг сонирхож байгаагүй учир тэдний бичсэн эх сурвалжийн агуулга нь нэг талыг баримталсан зэрэг дутагдалтай. Хятадын түүхчид гадаадынхныг зэрлэг бүдүүлэг мэтээр дүрсэлэхээс гадна Төв болон Өвөр Азийн ард түмэнтэй хийж байсан худалдаа арилжаа, эдийн засгийн харилцааны талаар баримт мэдээ ховорхон бичиж үлдээжээ. Хэдий тийм боловч “магадтай” түүхэн бичвэрт дипломат болон албан татварын хүрээнд харилцаж байсан харилцааны

¹ МУИС-ийн ГХСС-ийн Хятад судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

тухай мэдээ занги нэлээд бий. Өнөөг хүртэл цөөн эрдэмтэн Мин улс Төв Азийн харилцааг судалж ирсэн ббөгөөд XIX зуунд хамрах бүтээл нь өмнөх түүхэн судалгаанаас шальтай хальсан зүйлгүй гэж үздэг. Гэхдээ сүүлийн 20 жилийн явцад Япон, Хятад болон Барууны эрдэмтэд арай дэлгэрэнгүй нарийвчилсан судалгаа хийж түүхэн мэдлэгийн санг анивжуулж байгаа билээ.

Мин улсын гадаад бодлого нь, хөрш улсуудтайгаа харилцаагаа хумих ялангуяа умард хөршүүдээсээ аль болох зайлсхийх бодлогод тулгуурлаж байлаа. Монголын байлдан дагуулагч хаадын эрхшээлд зуун жилийг өнгөрөөсний эцэст тусгаар тогтножээ. Эндээс харвал Монгол болон бусад Төв Азийн улсуудын түрэмгийллээс сэрэмжилдэг байсан бололтой. Мин улсын бодлого хоёр үндсэн санаанд хуваагдсан ба энэ нь Мин улсын үеэс цаашид баримталсан бодлого бүрэлдэхэд тун чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болно. Хятадын түшмэд Хятадын ертөнцийг үзэх үзлийг хөршүүддээ дэлгэрүүлэхийг чухалд үзэж байлаа. Гэтэл умард хөршүүдтэй хийсэн худалдаа наймаанаас Хятадын талд орж байсан эдийн засгийн ашиг нь тоомсорлохгүй байх аргагүй байсан юм. Энэ арилжаанаас ашиг олж байсан наймаачид болон зарим түшмэд мэдээжийн хэрэг умард хөршүүдтэйгээ худалдаа хийх сонирхолтой байснаар барахгүй харилцаагаа өргөжүүлэх оролдлого байнга хийсээр иржээ. Оордоос худалдааг хориглох, хязгаарлах зарлиг гарсан ч худалдаачид болон зарим түшмэд хууль дүрмээ зөрчиж умард хөршүүдтэйгээ нууцаар хилийн худалдаа хийж байв.

XVI зууны үеийн Монголд улстөрийн бутрал улам гүнзгийрч, Монголын их хааны угсааны ноёд хүчирхэгжиж хаанаас янз бүрийн шан хишиг, хэргэм зэрэг нэхэн шаардах болсон ажээ. Барсболд жононг нас барсны дараагаар түүний хүү Гүнбилэг мэргэн жонон (1505-1550), Алтан хан нар баруун гурван түмнийг дараалан захирсан үед Монголын дээд хэсгийнхэн дундаас Алтан хамгийн нөлөө бүхий нь байжээ.

Судар бичигт тэмдэглэснээс үзвэл "...Хятад зөвшөөрвөл би Мин улсад элсэх зөвшөөрлийн бичиг олж авна. Тэгвэл Цагаан хэрмийн доторх газрыг чи эзэмшин тариал. Би Цагаан хэрмийн гаднах газрыг эзэмшин нутаглана. Хэрэв намайг эс зөвшөөрвөл, би эрхбиш хэдэн түмэн морьтныг авч Цагаан хэрмэнд саатахгүйгээр уулгалах болно..." гэжээ.

Дээрх баримтаас үзвэл тухайн үед Алтан хан Мин улстай худалдаа хийхийн тулд найрамдалт харилцаа тогтоохыг зорьж байжээ. Үүнийг эрдэмтэн Х. Серройс "Алтан ханы вассал болох хүсэлтүүдийн нэг" гэжээ.

Алтан хан вассал (түшмэг) болох хүсэлтээ зүгээр нэг гаргаагүй бөгөөд тэр үед зөвхөн дээрх нөхцлүүдийг тавьж, буулт хийх замаар Мин улстай найрамдаж худалдаа, арилжаа хийх гэсэн Алтан ханы дипломат бодлого байсан байж болох. Нөгөөтэйгүүр тухайн үеийн тархай бутархай Монгол улсыг нэгтгэх болон газар тариалан, гар урлал хөгжүүлэх Алтан ханы бодлогод Хятадын Мин улсыг саад болгохгүйн тулд тийм хүсэлтийг гаргажээ. Захидалдаа цааш нь болзол тавьж Цагаан хэрмээр хиллэн бие биенийхээ эзэмшин захирах нутгийг тогтоох санал тавьсан байна. Хэрэв эдгээрийг хүлээн авахгүй бол уулгалан дайрах тухай сүрдүүлжээ.

"Алтан ханы намтар" -т тэмдэглэснээр бол Алтан хан 1533-1558 оны хооронд Мин улсыг 9 удаа аялан дайлж, их хэрмийн дагуу хот, сууринг уулгалан дайрч үлэмж хэмжээний олз ашиг олсон байна. Энэ нь нэг талаар Мингийн тал Алтан ханыг үл ойшоож байсны хариуд авсан хариу арга хэмжээ, нөгөө талаар дээр өгүүлсэн эдийн засгийн хомсдолоо нөхөх арга байжээ. Эзэмшил газраа өргөтгөх зорилгоор Урианхай, Ойрад, Түвэд рүү довтолж тэднийг эрхшээлдээ оруулахын

тулд Мин улстай найрамдалт харилцаа тогтоох, гадаад харилцаагаа бэхжүүлэх хэрэгтэй байсан учир Мин улс руу элчээ илгээж байсан. 1547 онд Алтан хан Мин улсыг уулгалахаа түр зогсоон элч илгээж, найрамдах санал бүхий захидал хүргүүлжээ. Уг захиандаа:

“... Өнөөдрөөс эхлэн гадаад цайзын харьяат чинь больё. Тэгээд би зүүн этгээд Ляодунгаас баруун этгээд Тань Лян хүртэл хязгаараар нэг ч морьтонг танай хилд алхуулахгүй байя” хэмээжээ.

Энэ захиатай холбоотой нэг сонирхолтой баримтыг “Ван Ли У гун лу”-д тэмдэглэжээ. Түүнд: “...Тэр өдрөө Мэнгбайтайсанд тушааж нэг хувь монгол бичиг бичүүлэн, хажуугаар нь хятад үсгээр тайлбар бичүүлэн тамга дарж Ли Тянь Цзюе нарын дөрвөн хүнээр уг бичгээ хүргүүлэн Хятадын талд орчуулсан...” гэжээ.

Монголчууд XIII, XIV зууны үед гадагш явуулж байсан захидлаа төрөлх хэлээр бичиж хажууд нь тухайн улсын хэлээр орчуулж, дор нь тамгаа дардаг байжээ. Дээрх захидал мөн уг горимын дагуу үйлдэгджээ.

“Ван Ли У Гун Лу” -д цааш нь тэмдэглэснээр “... Зургадугаар сард Аньда, Бадуэ, Гуань эр тайж нар улам бүр ухралт цөхрөлтгүй хил дээр ирж торго цэмбэн хувцас, улаан өнгийн элдэв цэмбэ зэргийг гуйв. Тэгэхдээ өргөмөл хүү Лю Гэнь цзыгээ бичгийн хамт өргөн барив”. Боолын нийгмийн үед бий болж, феодалын нийгмийн үед өргөн хэрэглэгдэж байсан гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөх зарчим *facto sunt servanda* ёсоор амласандаа хүрэхээ илэрхийлж, баталгаа болгон өргөмөл хүүгээ өргөн барьсан мэтээр хятад сурвалжид тэмдэглэсэн байдаг. Гэвч энэ тухай Монголын сурвалж бичгүүдэд өөр өөрөөр бичсэн, түүнийг Барууны болон Японы эрдэмтэд тайлбарласан байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Мин улс Алтантай харилцаа тогтоохыг дахин эрс татгалзаж монголчуудын довтолгооноос сэргийлэн Бээжингээс Монголын хил рүү цэрэг яаралтай татах тухай зарлиг гаргажээ. 1550 онд Алтан хан Мин улсын эсрэг цэрэг хөдөлгөсөн бөгөөд Бээжингийн ойролцоо дөхөж очин алба өргөхийг зөвшөөрөх, мөн байнга их хэмжээний алт төлөхийг Мин улсаас шаардсан байна. Мин улс Алтан ханы шаардлагыг хүлээн авахгүй байсаар удалт зөвлөлдсөний эцэст 1551 онд хоёр талын хооронд найрамдалт харилцаа тогтжээ. Ингэхдээ Мин улс Алтан ханд Мин улсын нутаг дэвсгэрээс гарах урьдчилсан нөхцөл тавьсныг Алтан хан хүлээн зөвшөөрсөн байна. Найрамдалт харилцаа тогтсоны дараа Датун, Сюаньфу газарт худалдааны зах нээгдсэн аж. Гэвч удалгүй Мингээс монголчуудад будаа тариа худалдахаас татгалзсан байна. Алтан өөрийн зүгээс 1559 онд Мин улстай найрамдах зорилгоор Шэньсигийн цэргийн эрхтэнд элч илгээсэн боловч Мин улсын талаас нааштай хариу аваагүй ажээ.

1560 онд Мингийн талаас Алтан ханы нутаг руу гэнэт довтолж 150 хүн алж их хэмжээний түймэр тавиад буцжээ. Үүнд нь монголчууд дургүйцэн Мин улсын хил рүү улам их хүчээр уулгалан довтолж цаашид Мин улсын талд монголчууд тайван замаар арилжаа наймаа хийх бололцоо өгөхгүй бол Мин улсын хилийг байнга уулгалах болно гэдгээ сайтар ойлгуулжээ. Үүнээс үүдэн Мин улс, монголчуудтай зэвсгээр тэмцэх бус харин тайван замаар буюу хүндтэй цол, хэргэм, бэлэг сэлтээр татах, өөрөөр хэлбэл эсэр татах аргад шилжсэн ажээ.

1570 онд Мин улсаас Алтан ханд “Шунь И ван” (журмыг дагагч ван Д.У) хэмээх цол өргөмжлөхийн хамт түүний доод 60 гаруй ноёд, тайж нарт элдэв цол шагнал олгоод Монгол, Мин улсын хооронд хэвийн харилцаа дахин сэргэж, дараа жил нь Датун, Сюаньфу, Шаньси зэрэг дөрвөн

газар басар (зах) нээгдэж 12-14 хоног ажиллахад басар дээр монголчууд 28 мянга гаруй адуу худалдсан ажээ. Тэрчлэн жилд нэг удаа нэр бүхий ноёд, тайж нар Мин улсад алба болгон барих агтны тоог 500, хил дээр хүргэж очих хүн 150-иас тус тус хэтрэхгүй байх, Мин улсын нийслэлд агт хүргэх элчийн тоог 60 хүн байхаар тогтоожээ. Алтан хан ийнхүү Мин улстай харилцаагаа сайжруулсан явдал нь Мин улсад бууж өгсөн хэрэг бус харин чиглэсэн зорилго, тухайлбал бутралыг давж Монгол улсаа төвлөрүүлэхийн тулд нэг талаар гадаад байдлаа бэхжүүлсэн хэрэг байлаа. Аль нэг улс нөгөөдөө алба барих явдал Дорно дахины орнуудын дипломат харилцаанд аль эрт үеэс уламжлагдаж ирсэн түгээмэл үзэгдэл байсан юм.

XVI зууны сүүлийн хагасаас монголчуудын талаарх Мингийн бодлогод өөрчлөлт гарч, улмаар Хятад Өмнөд Монголтой найрамдахыг чухалчлах болжээ. Мин улс нь Өмнөд Монголтой эвлэрэх болсон явдал юуны өмнө Алтангийн довтолгоонд эрсэдсэний зэрэгцээ Дарайсун хааны хүү Түмэн (1558-1593) Монголын хаан ширээг залгамжилж авснаар Монголд улстөрийн хувьд нэгдэх үйл явц нэгэнт бий болж эхэлсэнтэй холбоотой байв. Хятад улс монголчуудыг улс төрийн хувьд нэгдэх явцад саад тотгор учруулах зорилгоор Алтан хантай найрамдаж, түүнийг Түмэн хааны эсрэг чиглүүлэх бодлого явуулахыг оролдох болжээ.

Гэвч тухайн үед Түмэн хаан, Алтан хан хоёрын хооронд засаг төр, эрх мэдлийн төлөө тэмцэл өрнөж байсныг анхаарахгүй орхиж болохгүй билээ. Зарим эрдэмтэн Алтан ханы улс төрийн үйл ажиллагааг дүгнэхдээ түүнийг Монголыг өөрийн ноёрхол дор оруулж нэгтгэх зорилт тавьсан нь эргэлзээгүй гэж үздэг. Үүнийг сурвалжууд дээрх зарим мэдээ нотолж байна. Тухайлбал, Алтан хан Мин улсын засгийн газарт бичсэн айлтгалаас харж болно. Түүнд өгүүлэхдээ: "... Хэрэв Мин улс түүнтэй найрамдваас Мин улсад Ляодун газар их хэмжээний өр хохирол учруулж байлаа. Түмэнгийн эсрэг тэмцэлд бэлэн" гэжээ. Мөнхүү айлтгалд "Мин улс надад Ван цол олговоос миний бие бүгдийг өөрийн эрхэнд оруулж чадна. Миний эсрэг Монголын удирдагч нараас огоорон тэмцэх зүрхтэй хүн гарахгүй" гэжээ. Нөгөөтэйгүүр Мин улс над лугаа найрамдалт харилцаа тогтохгүй тохиолдолд Түмэнтэй хамтарч Мин улс руу дайрна гэж тэр сүрдүүлж байжээ. Энэ мэтээр Мин улстай найрамдвал Монгол улсаа төвлөрүүлж захирахад тустай бөгөөд Монголын их хаантайгаа хүчин хавсарч Мин улстай тэмцэлдэх учраа ийнхүү анхааруулж байжээ. Үүнийг зөвхөн Алтан ханы санаа биш харин тэр үеийн Монголын эрх баригчдын бодлого гэж үзвэл зохино. Дээр өгүүлсэн баримт бичгүүдийг Монголын талаас гаргасан бичиг захидлууд гэж үзэж болох юм.

Бид Мингийн талаас гаргасан баримт болох Алтан хан Мин улстай найрамдаж, Мин улс Алтан ханыг ван цолоор шагнаж, түүнийг дагалдан гарсан 6 баримтыг олж хятад сурвалжид тэмдэглэгдсэнийг англи хэлээр орчуулсантай нь тулгаж орчуулсан билээ. Эдгээр баримтын эхнийх нь 1571 оны 4 сарын 21-нд Алтан хан "Шунь И ван" буюу журмыг дагагч ван цолоор шагнагдсан өдөр, түүнийг дотуур болон гадуур олон өмсгөлтэйгөөр залж Мин улсын эзэн хааны айлдсан зарлиг юм. Үүнд:

"Бид газар тэнгэрийн эрхийг судлаад хүний амийг аврах нь буянт хэрэг мөн гэж үзсэн. Урьдын хувилгаан эзэн богд мэргэн хаадаас тэнгэрийн эрхээр энэхүү ертөнцийг эзэгнэн захирч байсан. Тэд тэнгэрийн эрхээс зөрүүлж эзэн богд мэргэн хаадаас их тэнгэрийн эрхээр энэхүү гажуудуулсан зүйл нэгээхэн ч үгүй. Бас хүмүүсийн хүслийг харгалзан үзэж тэдний санаа, бүхий л ертөнцийг хамарч хятад болон хү нарыг (монголчуудыг хэлж байна. Д.У) нэгэн гэр мэтээр үздэг

байсан. Хятад бус хүмүүс энэ ертөнц дээр зэрэгцэн оршиж цугтаа хөгжин дэвжээсэй гэж байнга хүсдэг байсан. Бидний агуу их өвөг Тай зү эзэн богд Гао, тэнгэрийн хүчийг олж арван мянган бүс нутгийг захирсан. Бидний төгс өвөг Чэнзү эзэн богд Вэн тэнгэрийн эрхийг дагаж засгийн эрхийг өвлөн авч есөн хилийн газрыг хянан захирсан, дөрвөн далайн өмнө хойно аль ч зүгт тэдний эрхшээлд ороогүй гадуур үлдсэн үндэстэн үгүй. Алтан ургийг өвлөсөнөөс хойш таван жил болоод байна. Бид тэнгэрийг бишрэн дагаж өвөг дээдсийнхээ замлалаар амьд бүх юмыг нандигнан Хү, Юэ хоёрыг алаггүй найрсан хамтад нь тэжээдэг. Чиний хүү доройтож эхлэнгүүт хилийн түшмэдэд түүнийг хамгаалах, түүнд өмсөх хувцас идэх хоол хангаж өгөх тусгай зарлиг гаргасан. Түүнийг бид өгөөмрөөр бөөцийлж дараа нь хүндэтгэлтэйгээр үдэн мордуулсан. Бидэнд талархахдаа та бүгд өөрсдийгөө вассал (түшмэг) хэмээж, үнэнч холбоо тогтоож жил бүрийн алба барьж байх хүсэлтэй байна. Чи үнэнчээ илэрхийлж босуул хулгай нарыг барьж өгсөн, хилийн түшмэдүүд чамайг төлөөлөн айлдвар явуулдаг байсан. Умарт Хү нар үеийн үед алба гувчуур барьдаг байсан үнэнийг бид мэдэж байна. Манай хаант улсад үүний байнгын бүртгэл ч байдаг. Үнэнчээ харуулж манай зарлигийг гүн хүндэтгэлтэй эелдгээр гуйдгийг чинь тэнгэрийн эрхийг гүнзгий ойлгосны илрэл гэж үзэж болно. Чамайг үнэнхүү сайшаан хүсэлтийг чинь биелүүлэхдээ бид сэтгэл хангалуун байна. Чамайг журмыг дагагч ван цолоор шагнав. Чамд өгсөн, чиний дүү нар чиний хүүхдүүд мөн олон янзын омог аймгийн толгойлогч нарт бид Дү дү цолыг шагнахын зэрэгцээ үеийн үед өөрийн суугуул нутагтаа оршин уух ус, ан гөрөө эрэн, нутаг сэлгэх, бүхий л амьдын жаргалыг амсан энх тунх амьдрах эрхийг өгч байна. Тэнгэрийн нэрээр арван мянган орныг эзэгнэгч бид ойр хол гэж бусдыг алаглан үздэггүй. Тэнгэрийн гэрэл хүрсэн хэн боловч бидний хар үст ахан дүү нар мөн. Бидний сайн санааны дэмжлэг туслалцаа бүхэнд адилхан хүрнэ. Чи гадуурхагдан үлдэх шалтгаан огтхон ч үгүй. Хүндэтгэлтэйгээр дээш хар, тэнгэрийн эрхийг дага, үүргээ чанд биелүүлж өөрийн улсыг захир, байнга өгөөмөр эелдэг хүлцэнгүй бай. Ахмад хүмүүсээ амар амгалан байлга, залуусаа өсгөн хүмүүжүүл, бүс нутгаа хамгаал, олныг амгалан байлга, үеийн үед аз жаргалтай энх тунх амьдарцгаа. Хэрэв манай хаант улс тэнгэрийн эрхийг арван мянган жил дагаж чи болон чиний хүүхдүүд мөнхийн сайн сайхан үр дүн нь чамд таатай байх бус уу. Хэрэв чиний овог аймаг гол зорилгоосоо шалтаг хайн буруулж, манай бүсэд үймээн самуун гаргах юм бол тэд өөрсдөө энэхүү аугаа их төлөвлөгөөнөөс тэрсэллээ гэсэн үг. Чи андгай тангарагаа амархан эвдвэл тэнгэр газрын сүлд чамайг шийтгэн залхаах нь лавтай. Ингэвэл чи хэзээ ч аз жаргалтай байж чадахгүй. Бидний зорилгод нийцэгтүн. Үүнийг хүндэтгэлтэйгээр хүлээн ав” гэжээ.

Үүнд: Алтан ханы ач хүү Дайчин баатарын тухай өгүүлсэн байна. Монгол, Хятад сурвалжид энэ үйл явдлыг зөрүүтэй тэмдэглэсэн байдаг.

Хятад сурвалж бичигт 1570 онд болсон гэсэн бол Алтан ханы намтарт 1558 оноор тэмдэглэсэн байна. Дайчин баатарыг өвөг эцэгтэйгээ муудалцан Хятад руу зугатсан гэж Хятад сурвалжид тэмдэглэсэн байдаг бол Монгол сурвалж бичигт Дайчин баатарыг Мин улсын нууц хотыг дайлахаар явахдаа Мин улсын цэрэгт баригдав гэжээ. Мөн түүнчлэн “Мин ши” (Мин улсын түүх), сударт Дайчин баатрыг Бага ач хэмээн нэрийдэх бөгөөд Бичи хэмээх бүсгүйг их хатнаа болгосон хийгээд Ордос нутгийн бүсгүйг бага хатнаа болгохоор төлөвлөж байтал түүний үзэсгэлэн гуаг Алтан хан анзааран харж тоон дурлаж энэ бүхнээс үүдэн Бага ач зарц шивэгчинээ дагуулан Хятадын хилийг даван Мин улсад очиж суусан хэмээн тэмдэглэсэн байдаг. “Ван Ли

У Гүн Лу"-д Алтан ханы айлтгал бичигт: "... Хуанди миний зугатан шилжсэн үрийг сурган хүмүүжүүлж өөдлүүлсэн ач тус хэмжээлшгүй. Тиймийн учир би дуртайяа гадаад түшмэл чинь болж орон нутгийнхаа юмаар алба барьсугай..." гэсэн байдаг.

Хоёрдугаар бичиг

1571 оны тавдугаар сарын 13-ны Мин улсын эзэн хаан 63 язгууртанд цэргийн хүндэтгэлийн цол шагнажээ. Яг тэр үед зөвхөн Түмэдийн жононгууд хүндэтгэлийн цол хүртсэн юм. Хоёр сарын дараа, долдугаар сарын 5-нд Ордосын жонон түүний 48 хамаатан адил цолоор шагнагдсан. "Мин ши" (Мин улсын түүх), "Мин ши лу" (/Мин улсын үнэн магад тэмдэглэл) хоёрт эдгээр цолыг шагнасан тухай баримтаас өөр дэлгэрэнгүй зүйл байдаггүй бол "Ван Ли У Гүн лу"-д энэ үед буулгасан зарлигийн эх байдаг ажээ. Тухайлбал:

"Бид тэнгэрийн нигүүлслийг хүртэж арван мянган улсыг эзэгнэгч болсон. Бидний сонирголоос эд баялаг нь ангид үлдсэн гадаадын газар орон холын бүс нэгээхэн ч үгүй, хэрвээ тэд чинхүү үнэнч байж чадах юм бол бидний дорх харъяатууд байж, хол ойр гэж алагчлалгүй байж чадна. Ойроос бидний тус дэмжлэгт Алтан үнэнчээр зүтгэх болж чамайг алба гувчуур барьж вассалуудын нэгэн болохыг уриалах болсон. Энэ бол чиний үнэнч хичээл зүтгэл учраас бид чамайг голоос магтан сайшааж баясана. Бид Алтанг журмыг дагагч хэмээн онцгойлон цоллохын зэрэгцээ та бүхэнд бүгдэд чинь цол гуншин шагнаж байна... Чи ардын холбоо байгуулаад түүндээ үнэнчээр зүтгэх ёстой. Тэнгэрийн хаанчлалын гайхамшигт дулдуйдаж вассалын үүргээ чанд биелүүл. Хязгаарлашгүй өмгөөлөл дэмжлэгт нь багтан өөрийн арван мянган үедээ тэрхүү өвлүүлэхийн тулд завшаант үр дүн нь эрх биш сайхан байх бус уу" гэжээ.

Энэ зарлигийн гол утга нь, тэдгээр ноёдыг шагнаснаас гадна Алтан ханыг тэдэнд жишээ болгосон нь түүний нэр нөлөөг илтгэж байна.

Гуравдугаар бичиг:

Дээр дурьдагдсан 1571 оны дөрөвдүгээр сарын 21 ба тавдугаар сарын 13 (аргын тооллын) гэдэг он, сар, өдрүүд нь өмнөх бичгүүдийг гардуулсан өдрүүдийг зааж байна. Ван Чунгу гийн хооронд аль хэр удаж хүрсэн нь мэдэгдэхгүй байна. Алтан хан түүний хөвүүд, ах дүү нар энэхүү хоёр бичгийг хэдийд гардан авсныг "Мин ши лу" (Мин улсын үнэн магад тэмдэглэл)-гээр дамжуулаад ч мэдэж чадсангүй. Алтан ханы Шунь И ван цол шагнуулахад байгуулсан хэлэлцээр, хоёр орны харилцааны дүрмийн эх хятад сурвалжид хадгалагдаж үлдсэн байдаг. Энэ эхийн эхний мөр нь Алтан хан ван цолоор шагнагдсан үе буюу Лун Чэний V оны тавдугаар сард гэсэн мэдээг Х. Серройс дурьдсан байна.

1. Бууж өгсөн ард олны хувьд хэрэв тэд алба гувчуурын цогцыг хүлээн авахаас өмнө ирсэн бол энэхүү зүйлд хамаарахгүй. Өнөөдрөөс эхлэн хойд бүс нутгийн ямар ч хүн Хятадад нэвтрэн орвол тэднийг жинхэнэ хү гэж үзэх ба хүн, морийг нь хүчээр буцааж гаргана. Монголоос ирж буй Хятадын уугуул иргэд Хятад руу нэвтрэхэд гэр бүлийн аль гишүүд ая тухын харамж авна. Үүнд: 4 хуй бөс даавуу. Хэрэв тэр гэр бүлийнхээ гишүүд дотор олзны хүн авч яваа бол урьдын адил түүнийг нь буцаана.

2. Хятадын суугуул иргэд хойд нутагт дагаар орохоор ирэх юм бол монголчууд тэднийг баривчлан буцаадаг байсан. Ингэсэн монголчууд өндөр шагнал авдаг байв. Монголчуудын хэн нэг нь ямар нэг хятадыг нууцаар хулгайлан хил давуулж Монголд авчрах юм бол нэг дор 9 үхэр, 9 хонь, 9 адуугаар торгуулна.

3. Хэрэв монголчуудын нэг нь хүн алах юм бол алагдсан хүнийхээ тоогоор 9 дахин илүү буюу 81 толгой мал дээр нь нэмээд 1 тэмээ өгөх ёстой. Хэрэв хятад суугуул монголыг албал Хятадын хуулийн ял эдэлнэ.

4. Хэрэв Хятадын уугуул нь монголчуудын адуу, үхэр, хонь, бөс даавуу хулгайлбал, хулгайлахаар Монголын хилийг зөрчөөд газар дээрээ баригдвал Хятадын хуулийн дагуу шийтгэгдэнэ.

5. Ямар нэг шалтгаангүйгээр хятад хүнийг зодвол монголыг нэг адуугаар торгоно.

6. Монгол хүн Хятад руу нууц хаалгаар орж болохгүй. Хулгайгаар Цагаан хэрэм рүү авчирч байгаад баригдвал хүн бүхэн 9 адуу, 9 үхэр, 9 хониор торгуулна.

7. Хэн нэгэн монгол хүн хятад хүний эд зүйл хувцас хунарыг хулгайлбал 5 толгой малаар торгуулна.

8. Хэн нэгэн монгол хүн сүх, хадуур хулгайлбал нэг хониор торгуулна. 4 юм уу 5 ширхгийг хулгайлбал 1 үхрээр торгуулна.

9. Хэн нэгэн монгол хүн албан ажлаар явсан хүнийг зодвол 9 үхэр, 9 хонь, 9 адуугаар торгуулна.

10. Хэрэв хэн нэгэн монгол малгай, нусны алчуур хулгайлбал том жижиг хамаагүй өөр зүйл, бас бус зүйл хулгайлбал 1 хониор торгуулна.

11. Хэн нэгэн монгол хятадын морь, луус, илжиг, үхэр, хонь хулгайлбал малын толгой бүрийг 3 нугалан төлнө.

12. Хурим найрын үед гэр ахуйн эд зүйл хулгайлбал 1 хониор торгоно.

13. Монголчууд алба гувчуур төлснийхөө шанд хааны шагналыг авбал өөрсдийнхөө морь, луусыг нэг насаараа унах эрхтэй болдог. Их зээлийн газар нээгдэж яаралтай хэрэг зарлагдсан байвал ван болон хун тайжид 4 морь, бусад тайж морь шилжүүлэх албаас хэлтрүүлнэ.

14. Хэрэв тэд шан харамж горилон эсвэл адуу мал зарахаар ирвэл хүн хүн өөрийнхөө морийг унаг...”

Энэ баримт бүхэлдээ Монгол, Мингийн худалдаа, улс төрийн харилцааны өвөрмөц шинж, хэм хэмжээг илэрхийлдэг байна. Үүнээс харахад Хятад нутагт худалдааны юм уу, өөр ажлаар ирсэн монголчууд элдэв гэмт хэрэг үйлдэх явдал их байсныг харуулж байна.

“Ван Ли У Гүн Лу” дотроос Алтан хан түмдийн бусад жононгуудын хамт яг хэдийд Мин улсад хүчин зүтгэхээ албан ёсоор тангараглаж хүндэтгэлийн цол шагнуулсан тодорхой он, сар, өдрийг олсон нь зургадугаар сарын 13 (билгийн тооллын) буюу тавдугаар сарын 21 (аргын тооллын) юм. Алтан ханы хүсэлт Мин улсын хаанд зөвшөөрөгдөж, түүнд зарлиг бичиг гардуулах ёслолын өдрийг товлосныг Ван Чингу анх мэдээлсэн гэж Х. Серройс таамаглажээ.

Чюй Жю Сы гийн тэмдэглэснээр ёслол Датанаас хойш Тө Шин Пу гэдэг жижиг хотын хойно яг Цагаан хэрмийн хажууд болжээ. Хятадууд морьдын хөлс хатаадаг талбай буюу Лян Ма Тай гэдэг Мин улсаас өгдөг шагнал байв. Энэ баримт бичиг нь шан харамж, худалдааны эрх олгох итгэмжлэл байсан болов уу. Учир нь профессор Ва Да Сей “... Хааны зөвшөөрөл нь харамж төлөх юм уу, худалдааны лиценз байсан...” гэсэн байдаг. Монголчууд энэ бичгийг Юань улсын үеийн

Бээжингийн нэрээр Дайду гэж нэрлэдэг байжээ. Тэдгээр бичгээс гадна Алтан ханд ирсэн бэлэг дотор урт өмсгөл, хэд хэдэн дотуур хувцас байжээ. Тийнхүү зургадугаар сарын 13-нд Алтан хан монголчуудаа дагуулан хааны зарлигийг сонсохоор иржээ. Хятад сурвалж бичигт тэмдэглэхдээ: “Алтан хан өмнө зүг харан толгойгоо доош мэхийн 4 удаа ёслоход Хятадын түшмэл эзэн хааны зарлиг бичгийг уншиж эхлэсэн. Уншиж дууссаны дараа Алтан хан талархлын ёслол үйлдээд дахин газар сөхөрч малгайгаа авч мөн л доош мэхийн ёслов” хэмээжээ.

Түүнд энэ талаар, монголчуудын заншлаар бол малгайгаа аваад толгойгоо доош мэхийн ёслох нь хүндэтгэл хэмээн нэмэн тайлбарлажээ. Гэтэл энэ хүний тэмдэглэлд монголчууд Хятадын хилийг уулгалан зөрчихгүй байх хатуу ам тангарагийн тухай огт дурьдаагүй нь хачирхалтай байна. Гэхдээ уг бичгийн эхний мөрд энэ тухай бага боловч цухалзуулсан байдаг. Х. Серройс үзэхдээ Алтан хан шадар хүмүүстэйгээ тушаал дэвшүүлсэн зарлиг хүлээн авахаасаа өмнө тангараг өргөсөн гэжээ. Эдгээр дүрмийг бичсэн хэллэг нь өмнөх хуудсуудад орчуулсан хоёр бичгийнхээс тэр чигээрээ өөр байна. Лян Ма Тайгийн ойролцоо болсон ёслолын үйл ажиллагаанд оролцсон монгол орчуулагч нар бичиж тэмдэглэсэн болов уу гэжээ. 1571 оны хэлэлцээрийн эх бичиг нь 1577, 1603, 1613 оныхтой ижил төстэй онц чухал нөхцөл байдалд тунхаглагдсан байж магадгүй хэд хэдэн өгүүллэгийн цомгийг багтаадаг. Лун Чэнгийн V жилийн 5 дахь сард Алтан хан бүхий л тайж, зүүн баруун гарын бүхий л овог аймгуудын ахлагчид дээр дурьдсан хууль дүрэм хэлэлцээрүүдийг хамтран тунхаглажээ.

Дөрөвдүгээр бичиг

Ван Лигийн (1577) V онд Шунь И ван III Далай ламтай уулзахаар баруун зүг явахдаа, хоёр дахь удаагийн цааз дүрмийг тогтоожээ. Түрүүчийн үйлдсэн бичигт хавсарсан 5 өгүүлэлт, 5 зүйлийн цаазыг нэмжээ.

1. Хилийн нэвтрэн өнгөрөх харуулыг хариуцсан монголчууд тухайн тосгодын хүрээнд багтсан хүмүүсийг Хятадаас гарахыг сэргийлж хянан эргүүл хийнэ. Мөн хулгай элдвийн будлиан гарахаас сэргийлнэ. Тухайн бүсийн тосгодын орон нутгийн цагдаа нартай хамтран хулгайч дээрэмчдээс сэргийлэхийн тулд хилийн замыг өглөө бүхэн манана.

2. Хилийн дамжуулан өнгөрөх хэсгийг хариуцсан монголчууд тухайн тосгодын хүрээнд багтан хүмүүсийг Хятадаас гарахыг сэргийлэн эргүүл хийнэ. Мөн харуул зэрлэгүүд хилийг нэвтрэн өнгөрөх зааг дээрээс Хятадаас гарсан хүний мөр олдвол мөрийг нь нэхэн хөөж баривчилсны дараа нөгөө талын харуулуудад тушаана.

3. Хэн нэгэн хүн Хятадаас гарч явсныг эзэн нь мэдээгүй, харуул мэдээд түүний үхэр морь хулгайлсныг мэдэж байсан нөхцөлд хуйвалдсан харуул нэг мориор торгуулна.

4. Янз бүрийн хот тосгодоос түлшний мод түүхэд нь даган явж орой буцахад дагалдан явсны хөлсөнд 2 хуй бөс 8 хуй даалимба авна.

5. Хэн нэгэн тайж дээрэм хулгай хийж олиггүй муу юм хийх гэж их бага олон зуун морьтон хүмүүсийг дагуулан хил нэвтэрвэл энгийн хүн 1 мориор, тайж хүн болгон 1 тэмээгээр торгуулна гэж заажээ.

Дээрх дүрэм нь “Мин ши лү” (Мин улсын үнэн магад тэмдэглэл) -д байх бөгөөд энд хилийн харуул хамгаалалтын асуудлыг нарийвчлан тусгажээ. Бүхий л овог аймгуудын ахлагч нар дээр дурьдсан хууль дүрэм хэлэлцээрүүдийг хамтран тунхаглажээ.

Тавдугаар бичиг

Энэ баримт бол 1571 онд Алтан хан нарын зэрэг Өмнөд Монголын ноёдоос Мин улсын хаанд өргөсөн айлтгал юм. Уг айлтгалын “Ван Ли У Гун лу”-гаас авсан Х.Серройсын англи орчуулгыг үзвэл:

Хойд Дигийн шинэ өргөмжлөгдсөн түшмэл Шунь И ван Амда нар хичээнгүйлэн их Мин улсын нигүүлсэнгүй тэнгэрлэг хааны өлмийд сүсэглэн биширч айлтгах нь: ... Урьд жил Сяо ван цзы албанаас алба барьж эхлэн эрхэм улсын шагнал хайрыг хүлээсэн бөлгөө. Ойрын жилүүдэд манай олон аймгийн хүмүүс зальхай хүний өдөөх мэхэнд автагдаж, тохинуулал шагналыг алдсан билээ. Түшмэд бидний хүн амын тоо өдөр ирэхүйеэ олширч хувцас хунар маш дутагдах болов. ...Гэтэл олон хязгаарт басар нээхийг зөвшөөрөхгүй тул хувцас хэрэглэлийн зүйл цөм олдохгүй болоод эсгий, нэхийгээр зуны халууныг тэсвэрлэхэд нэн бэрх болж, торго бөсийн зүйл ер олдохгүй болсон тул удаа бүр зальхай Чжао Чуань нарын хатгалгаар хил давж ороод, элдэв муу хэрэг хийж, бага сага зүйл олзлон авдаг байсан боловч хүн ба агт морьд алагдаж сүүддэг байв. Тэрчлэн сүүлийн жилүүдэд эрхэм улс хилээсээ байнга цэрэг хөдөлгөн манай хүн ардыг алан хядаж, морь мал хөөн аваачдаг боллоо. Бас хилийн наадах өвс бэлчээрийг түймэрддэг тул, хүн мал өвөл хаврын гачаал цагийг өнгөрөөхөд тун бэрхтэй болж байв.

...Тэнгэрлэгийн хаан зарлиг соёрхож, түшмэлийг Шунь И вангийн хэргэм, дүү... бусад хөвүүд ач, үеэлийн хөвүүдэд тус бүр... зэрэг хэргэм олгон өргөмжилсөн нь бүгд 57 хүн болжээ. Бас түшмэлд алтан хээтэй улаан магнаг дээл нэг зах, дээлийн өнгөт торгон дотор гадар 8, дүү болон хөвгүүдэд тус бүр арслан хээтэй улаан торгон хувцас нэг нэг, зах, дээлийн өнгөт торгон дотор гадар дөрвийг шагнаж, түшмэлээс алба барьж, басарт арилжаа хийхийг зөвшөөрсөн тэнгэрийн хишигт цаглашгүй талархан сүсэглэж байв. ...Бид жил бүр алба барьсагуй. Харин хил хязгаарыг сахигч олон түшмэд зарлан мэдэгдэж, басар нээлгэн монгол, хятад хүмүүс жил бүр харилцан арилжаалахыг гуйн айлтгана.

Жил бүрийн хавар түшмэд бидний элч боомтоор ормогц хугацаа тогтоож төгсмөгц монгол, хятад хүмүүсийг тарааж тус тусыг амар жимэр амьдруулбаас түшмэд миний үр ач нар үеийн үед өршөөл хишигт бишрэн шүтэж аймшиггүй урван тэрслэхгүй болох буйзаа. Хэрэв зөрчигчид гарваас тэнгэрийн гэгсгээлийг амсана. Түшмэлээс дээдийн хишиг өршөөлд цаглашгүй бишрэн сүсэглэж туйлын талархлыг илэрхийлэн айлтгах бичгийг олон аймгуудын алба болгон барьсан 500 агтын хамт хичээнгүйлэн өргөж байгаагаа дээдийн сонорт дэвшүүлэн барив. Өргөсөн зүйлүүд: Дээдийн соёрхон хэрэглэх мөнгөн эмээл хазаартай цагаан морь нэг, дээдийн соёрхон хэрэглэх морь 8, албанд барих морь 500 гэжээ.

Алтан хан нараас Мин улсын хаанд өргөсөн айлтгал нь хоёр улсын харилцааг хэвийн болгоход голлон чиглэсэн байна. Энэ айлтгалд Мин улсын төрөөс Монголын эсрэг явуулсан улс төр, худалдааны бодлого тод илрэн гарч байна.

Тухайлбал, Мин улс худалдааг нээхгүй болсон үед монголчууд суурьшмал орны бараа таавараар гачигдах явдал байнга гарч байв. Үүнээс болоод монголчуудын зарим нь Мин улсын хилд цэрэглэн халдах болдог. Мин улс ч үе үе Монголын хилд цэрэглэн халдах явдал гардаг. Үүнийг дипломат шугамаар зохицуулах гэсэн Алтан ханы оролдлого дээрх айлтгалаас харагдаж байна. Алтан хан энэ айлтгалд “сүүлийн жилүүдэд эрхэм улс хилээсээ байнга цэрэг хөдөлгөн

манай хүн ардыг алан хядаж морь мал хөөн аваачдаг болжээ. Бас хилийн наадах өвс бэлчээрийг түймэрддэг тул хүн мал өвөл, хаврын гачаал цагийг өнгөрөөхөд тун бэрхтэй болж байв” гэсэн нь үүнийг гэрчилж байна.

Дээрх бичгүүдээс үзэхэд Мин улсын ордныхон гадаадынхантай хэрхэн харилцах талаар онолын систем боловсруулсан ба уг системээ гадаад харилцаандаа хэрэгжүүлэн мөрдөж ирсэн гэсэн үзэл батлагдах талтай юм. Энэ системийн үндэс бол улсаа Дундад улс хэмээгээд бусад бүх гадаад хөршүүд түүнд хандив татвар өргөдөг улсууд гэж үзэх үзэл бөгөөд Хятад хаан бол бусад бүх гүрний хаадаас илүү хүчирхэг, бусд гүрний хаад татвар хандив өргөснөөрөө хятад хааны ханлиг мөн гэж үздэг байжээ. Хятадын түшмэд гадаад элчин сайдын хэдэн удаа ямар давтамжтай, хэчнээн олон бараа бологсодтой, ямар зам боомтоор ирэх очихыг нарийн зохицуулж ирсэн. Тэд Хятадын хаанд бааралхахдаа өргөл хийж хятадын ноёрхлыг сохороор хүлээн зөвшөөрч байгаагаа илэрийлдэг бэлэг тэмдгийн ёслол гэж хятадууд үзэж байжээ.

T.F. Tsiang хэмээх гадаад харилцааны энэ өргөл хандивын онолыг дэмждэг судлаач Хятад улсын гадаад бодлогын гол зорилго нь хил хязгаараа хамгаалах явдалд оршиж байсан гэсэн санааг дэвшүүлжээ. Түүний үзлээр бол Хятадын бодлогод гадаадаас барьсан өргөл хандивын үнэ цэнийн хэмжүүр нь чухал биш байсан байна. Харин ч Хятадын талаас хариуд нь өгсөн бэлэг хишиг нь үнэ цэнийн хувь гадны хандиваас хэд дахин илүү байсан бөгөөд тухайн гадаадын элчинг эрх бүхий элчин сайдын хувьд ийнхүү (Хятад их гэр бүл)-ийн нэгэн гишүүн боллоо гэсний бэлэг тэмдэг болгон маш их үнэ цэнэтэйд тооцогдож байсан луутай алтан хоргой дээл хувцас (ming –chi gedeg ertnees aldartai horgoi tongonii dardas hee) болон элдэв гуншин хэргэм зэрэг өгдөг байжээ. Тийнхүү Хятадын хааны хүртээсэн хишиг тийм их үнэ цэнэтэй ховор эд зүйлс байсан бөгөөд хятад худалдаачидтай явуулж байсан худалдаа наймаанаас Төв Азийнхан хятад түншүүдээсээ хэд дахин илүү ашиг олдог байсан байна. Харин хааны ордны түшмэдүүд хятадын гадаад бодлогын ёслол бэлэг тэмдгийн чанарыг худалдаа арилжааны талаас илүү дээгүүрт үзэж ихээхэн ач холбогдол өгч байсан. T. F. Tsiang “Хятадын хааны ордон энэхүү гадаадын өргөл хандиваас ашиг олж гавьсан юм үгүй” гэж дүгнэсэн байна. T.C. Lin хэмээх түүхийн уламжлалт тайлбарыг дэмждэг өөр нэг эрдэмтэн “Хятадын улс төрийн зүтгэлтнүүд өнөөг хүртэл гадаадтай харилцах энэхүү өргөлийн хариуд хишиг шан харамж хүртээх харилцаагаа хэзээ ч эдийн засгийн талаас нь харж байгаагүй” гэжээ. Мөн эрдэмтэн John Fairbankiin үзэж байснаар тэрхүү гадаад хөршөөс өргөсөн өргөл хандиваас Хятад хааны санд орсон ашиг гэвэл даан ч хомс, гадаад хөршөөс өргөсөн өргөл хандивт хятадуудад хэрэгтэй юм юу ч байгаагүй, харин ч худалдаа хятадуудад яршиг төвөгтэй асуудал байсан ажээ.

Гадаадын хаад ноёдын байр суурь энэ системд хэдий доогуур зиндаанд байсан ч харилцаа нь ихээхэн ашигтай байсан. Нэгдүгээрт, тариа буудай, гар урлалын бүтээгдэхүүн,цай зэрэг байнга эрэлхийлж байсан ховор бөгөөд зайлшгүй хэрэгтэй бараагаа хил дээр худалан авах юм уу хил дамнасан жин хөсгийн замаар тээвэрлэж авч байв. Хоёрдугаарт, Төв Азийн хаадууд нэр сүрээ хятад хаанаас хүртсэн хишгээр ихэсгэж өөр хоорондоо өрсөлддөг байж. Гуравдугаарт, хэрэв өөр нэгэн хөрш хил нэвтрэн орж дайн өдөөвөл, мөн энэ нь Хятадын сонирхлыг хөндөхүйц нутаг дэвсгэрт болвол тийнхүү Хятадын цэрэг дайны тусламжид дулдуйдаж болох байв. Ойрын жилүүдэд өргөлийн хариуд хишиг хүртээх гадаад бодлогын тухай судлаачид ихээхэн маргасан бөгөөд энэ таамаглал ирээдүйд өөрчлөгдөж ч болохыг үгүйсгэхгүй. Хятад улс Төв болон Өвөр

Азийн ард түмэнд ертөнцийг үзэх их гүрний үзлээ үеийн үед тулгаж нэвтрүүлж чадаагүй бөгөөд ялангуяа тухайн нэгэн хааны төр барьж байсан угсаа үе сулран доройтох үед бол бүр дурдах ч хэрэггүй. Тэд хөрш зэргэлдээ улс, овог аймгууд болон цөл хээр газарт өөрийнхөө ноёрхлыг тогтоож чадаагүй учраас хилийн худалдаанд явуулж байсан хязгаарлах бодлогоо мөн хэрэгжүүлж чадаагүй. Мөн сүүлийн үеийн судалгаагаар хятадын худалдаачид энэхүү хилийн худалдаанаас ашиг олж байсан бөгөөд энэ ашгийн төлөө тэмцэж тэмүүлж байсныг, зарим гадаадын зэрлэг бүдүүлгүүдээс орж ирж байсан зүйлс хятадад шальдар булдар бараа биш нэн чухал хэрэгцээтэй зүйлс байсныг нотолсон билээ. Мөн хятадын хааны ордны түшмэдүүдийн түүхэнд мэдээлсэн баримтнаас огт өөр зүйл илэрсэн нь юу вэ гэвэл, Хятад худалдаачид энгийн иргэд, засаг, хилийн худалдаа болон гаалийн тухай, дотоодын болон гадаад хөршийн улс төрийн байдлыг гайхалтай сайн мэдэж байсан явдал юм. Элч, хилийн түшмэд, цэргийн жанжин зэрэг хүмүүсийн үлдсэн түүхэн мэдээ нь тухайн үеийн Төв Азийн ард түмний амьдрал ахуйн үнэтэй материал агуулдаг. Товчоор хэлбэл, Мин улсын Төв Азитай хэрхэн сөргөлдөн учирч ирсэн түүхийг зөвхөн Хятадын хааны ордны баримталж ирсэн түрэмгий бодлогоор тайлбарлаж болохгүй юм. Бид дээр өгүүлсэн баримтуудыг олж үзсэнээр баруун түмнүүдийн жонон Алтан хан бол XVI зууны Монгол-Мингийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан төрийн зүтгэлтэн дипломатач байсныг мэдэж болно. Түүний дотоод, гадаад үйл ажиллагааг харуулсан хятад сурвалж бичигт дурдсан нь нэлээд олон байдаг. Тэдгээрээс бидний судлан буй зарим сурвалж бичгүүдийн үндсэн агуулгыг доорх байдлаар тодорхойлж болно. Үүнд:

1. Хятадын Мин улсын төрөөс монголчуудтай харилцсан бичиг захидал Монголын хаадтай эн тэнцүү харилцсан бичиг захидал зэргээс үзэхэд Монголын хаад ноёдтой эн тэнцүү харилцаж гэрээг албан ёсоор тунхаглаж байсан боловч хожим нь нүүдэлчидтэй харилцах харилцааны тухай хууль батлахдаа хятад хүнийг монгол хүний дээр тавьж хуульчилан заасан байна.

2. XV зууны Монгол-Мингийн харилцаанд энэхүү дипломат бичгүүд нь хоёр улсын харилцааны гол шинжүүдийг гаргахын хамт Монгол, Хятадын бие даасан улсын хэмжээнд харилцаж байсныг илэрхийлж байна. Мин улсын бодлого нь тэр үеийн дорно дахины улсуудын дипломат харилцаанд байдаг үйлдэл мөн.

3. Мин улсын хаад Монголын нүүдэлчидтэй харилцахдаа Хятад төвийн уламжлалт дээрэнгүй үзлийг баримтлан тэднийг ямагт өөрсдийнхөө хараат гэж үзэж байсан үзэл баримтлал энэ дипломат бичгүүдэд тодорхой байна.

4. Монголын хаадыг ямагт өөрсөддөө үнэнч байхыг шаардаж байжээ. Монголын эрх баригчдын дотор бол Хятад оронд урьдын Юань улстай адил ноёрхолоо тогтоох санаархал байсан нь Мин улсын гүн рүү байн байн довтлон цөмөрч байснаас илэрхий байна.

5. Хятадууд Монголын нүүдэлчидтэй хийх худалдаанд хориг тавьж төмөр эдлэл, зэвсэг худалдахыг хатуу хориглож байсан нь нэг талаар эдийн засгийн хавчин боох арга нөгөө талаар төмөрлөгийн зүйлсийг цэрэг стратегийн холбогдолтой гэж үзэж байсантай холбоотой хэмээн үзэж байна.

Ашигласан материал

Хятад хэл дээрх сурвалжууд:

1. 《明实录》
2. 《明史纪事本末》
3. 《明史》
4. (明) 瞿九思《万历武功录》卷十三《俺答汗列传》
5. 《明经世文编》
6. 《明辨斋丛书初集·皇明·九边考》
7. 《郑斋简公全集·吾学编·北虏考》
8. 《四库全书·史部传记类·蒙古王公表传》
9. (明) 陈洪谟、张瀚《松窗梦语》
10. 蒙文抄本《阿勒坦汗传》
11. 《罗·黄金史》
12. 萨囊彻辰：《蒙古源流》
13. 《阿勒坦汗法典》

Хятад хэл дээрх ном зохиолууд

1. 瞿九思：《俺答汗列传》，台北，1936年。
2. 留金锁：《十三世纪—十七世纪的蒙古历史稿》海拉尔市，1979年版。
3. 南开大学历史系：《中国历代名人辞典》，江西人民出版社，1982年版。
4. 沈起炜：《中国历史大事年表》，上海辞书出版社，1983年版。
5. 王国维：《黑鞑事略》，《王国维遗书》第13册，上海古籍书店，1983年版。
6. 阿·马·波兹德涅耶夫：《蒙古及蒙古人》，内蒙古人民出版社，1983年版。
7. 和田清：《明代蒙古史论集》，商务印书馆，1984年版。
8. 王辅仁、陈庆英：《蒙藏民族关系史略》，中国社会科学出版社，1985年版。
9. 留金锁：《蒙古史概要》第212页，内蒙古人民出版社，1985年版。
10. 杨绍猷：《俺答汗评传》中国社会科学出版社，1992年版。

Монгол хэл дээрх ном зохиолууд

1. 《Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх》，БНМАУ-ын ШУА，Улаанбаатар，1956
2. 《Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх》，БНМАУ-ын ШУА，Улаанбаатар，1966
3. 《Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх》，БНМАУ-ын ШУА，Улаанбаатар，1967
4. 《Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх》，БНМАУ-ын ШУА，Улаанбаатар хот 1976
5. 《Монгол Улсын түүх》，Монгол Улсын ШУА，Улаанбаатар хот，2003
6. 《Алтан ханы хууль》Ш.Бирагийн хэвлүүлсэн эх《Zentral asiatische studien》Bonn, 1973 (比拉出：《阿勒坦汗法典》《中亚研究》波恩，1973年。)
7. 《Алтан ханы үеийг ухуулсан эрдэнэ тунамал нэрт судар оршивой》бичмэл. ШУА-Түүхийн хүрээлэнгийн бичмэлийн хөмрөг. (《诸可汗源流黄金史纲》蒙古国科学院历史研究所草案资料馆)
8. Алтаншаа Н.《Монголчуудын өчигдөрийн мөр》1 дүгээр боть Улаанхад，1993. (纳·阿拉坦沙：《蒙古人的遗迹》，第一册，赤峰市，1993年。)
9. Ариунгуа Н.《Арван дөрвөөс арван есдүгээр зууны Монгол-Хятадын харилцаа》УБ., 1996 (纳·阿伦高娃：《14—19世纪的蒙古与明朝的关系》蒙古国科学院国际研究院，乌兰巴托，1996年。)
10. 《Арван дөрвөөс арван есдүгээр зууны Монголын гадаад харилцаа》УБ., 1997 (《14—19世纪的蒙古外交关系》，乌兰巴托，1997年。)
11. 《Ван Ли хааны цэргийн гавьяаны тэмдэглэл》Л.Жамсрангийн орчуулга УННС. (《万历武功录》俺答汗列传，扎木苏伦的翻译出编，蒙古国立图书馆。)

Бусад хэл дээрх ном зохиолууд:

1. Покотилов Д.《История восточных Монголов в период династии Мин》(1368-1634, по китайским источникам). СПб., 1893. (波格齐洛夫《明朝时东蒙古历史》(1368-1634, 中文史料 圣彼得堡 1893))
2. Свистунова Н.П. Организация пограничной службы на севере Китая в эпоху Мин.《Китай и соседи》. М., 1970. (斯维斯图诺娃《中国与他邻居》莫斯科 1970)
3. "Manchuria trade and tribute in the Ming dynasty," By T.C.Lin, Nankai Social and Economic Quarterly, 9 (1937)
4. "Trade and diplomacy on the China coast", By John K.Fairbank, Cambridge, Mass., 1953
5. Serryus H. Sino-Mongol Relations during the Ming. Brussels, 1967, 1975.
6. Serryus H. Sino-Mongol Relations during the Ming. The Tribute System and Diplomatic Mission (1400-1600) Brussels, 1967.
(塞瑞斯《明代中蒙关系：贡赋制度和外交使臣(1400-1600)，利时高等汉学研究所，1967》)
7. Serryus H. Four documents Realiting to the Sino-Mongol Peace of 1570-1571. Bruxelles, 1967.
8. "The Ming Emperor Yongle" By Shih-Shan, Henry Tsai, Journal of the American Oriental Society